

ЗДТГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ



ЭРХЭМ ЗОРИЛГО ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ, ЗОРИЛГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ТЭДГЭЭРИЙН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Байгууллагын стратеги, зорилго зорилт: ЗДТГазар нь сум орон нутгийн нийгэм, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэн төрийн удирдлагыг нутгийн удирдлагатай хослуулан төрийн үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу ард иргэдэд хөнгөн шуурхай ил тод явуулж, нутгийн захиргааны манлайлалыг дээшлүүлэх

Уриа

Оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх

Зорилт 1. Төрийн үйлчилгээний чанар үр дүнг нэмэгдүүлэх, иргэдийн санаачлага, идэвх оролцоог сайжруулах

Зорилт 2 мал аж ахуйг газар тариалантай хослуулан эрчимжүүлж усалгаатай тариаланг хөгжүүлэх

Зорилт 3. Орон нутгийн нөөцөд суурилсан дэвшилтэд технологид үндэслэсэн дэд бүтэц ЖДҮ, үйлчилгээг хөгжүүлэх

Зорилт 4. Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалж аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгальд ээлтэй морчин бүрдүүлэх Зорилго, зорилтуудаа хангах хүрээнд

сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт жил бүр чиглэл бүрээр тусган хэрэгжүүлдэг бөгөөд **2022 оны хөтөлбөрийн биелэлтийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал хэлэлцэн 93.4 буюу хангалттай гэсэн үнэлгээ өгсөн. Гол үр дүн Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх орчны бохирдолыг бууруулах зорилтот жилийн ажлын биелэлт 91,3 хувьтай хэрэгжсэн.** Малын тоо 5 төрөл дээрээ өссөн. Команд штабын сургалтыг суманд зохион байгуулж томилгоот бүрэлдэхүүнийг дадлагжуулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 1 иргэнд 5 сая төгрөг, хоршоог хөгжүүлэх сангаас 2 хоршоо, 4 иргэнд 119 сая төгрөгний зээлийг тус тус олгосон. Үүний үр дүнд төмс, хүнсний ногоо, малын тэжээл тариалдаг 2 хоршооны үйл ажиллагаа өргөжиж нарийн ногоо тариалах хүлэмж, зоорь болон тоног төхөөрөмжөөр хангагдан хоршооны 19 гишүүн ашиг хүртэнэ. Малын тэжээл тариалах, талбай хашаалах Талх, нарийн боов үйлдвэрлэхэд олгосон зээлийн хүрээнд шинээр байнгын ажлын байр 2, 4 иргэн ажлын байраа хадгалж үдийн цай, хүүхдийн цэцэрлэг болон иргэдэд шинэ, хямд гурилан бүтээгдэхүүнээр үйлчлэх боломж бүрдэж байна. Сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сүүний чиглэлийн үхэр үржүүлж байгаа иргэнд өгсөн бөгөөд орон нутагт үйлдвэрлэсэн цагаан идээгээр иргэдийг хангана. Хоол үйлдвэрлэгч 1 иргэнийг дэмжсэнээр бизнес хөгжлийн төвд байнга үйл ажиллагаа явуулж халуун хоол цайгаар үйлчилж 1 өрхийн амьжиргаа дээшилж байна.

/хуулийн 8.2.1/

АЖЛЫН БАЙРНЫ СУЛ ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ

/ Хуулийн /8.3.1/

1. Төгрөг сумын Засаг даргын тамгын газарт 1 орон тоо байна.
 - Мал аж ахуйн үйлдвэрлэлийн менежмент, малын бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн. Шаардагдах мэргэжил /мал аж ахуй, Зооинженер, технологи, Мал эмнэл зүй, менежмент ба удирдахуй/
2. Аймгийн мал эмнэлгийн газрын харьяа сумын Мал эмнэлгийн тасагт 2 орон тоо байна.
 - Тасгийн дарга /шаардагдах мэргэжил. мал эмнэл зүй буюу малын их эмч /
 - Тархварзүйч / шаардагдах мэргэжил мал эмнэл зүй буюу малын их эмч /

АЛБАН ХААГЧ, АЖИЛТНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

/хуулийн 8.3.2/

Албан хаагчийг ажилд авахадаа Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журмыг мөрдөн ажиллаж байна. Мөн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд албан хаагчийг ажилд авах, томилох заалтуудыг шинэчлэн оруулж батлан мөрдөн ажиллаж байна.

2022 онд удирдах албан тушаалтны сул орон тоо 1 ТЗ 9, хөдөө аж ахуйн тасагт 2ТЗ-3 нийт 3 ажлын байрны сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг хугацаанд төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж, иргэдэд ил тод мэдээлэн зарлуулсан. Зохих шалгалтад хамрагдаж тэнцсэн 2 албан хаагчийг томилон, ашиг сонирхлын зөрчилгүй гэсэн мэдээллээ шилэн дансанд тухай бүр байршуулсан.

Төрийн үйлчилгээний орон тоо 2 гарсан ба холбогдох хууль, журмын дагуу ажилд томилсон:

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ / хуулийн 8.3.4/

Төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн системд шинэчлэл хийсэнтэй холбоотойгоор системд албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон холбоо барих мэдээлэл мэйл хаяг болон бусад холбогдох мэдээллүүдийн өөрчлөлтүүдийг тусгасан. 2022 оны байдлаар жирэмсэний амралтаа авсан 1 албан хаагч, үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн 16 албан хаагч тус орон дээр томилогдсон болон сэлгэн, дэвшин ажиллаж байгаа 17 албан хаагчийн мэдээллийг тухай бүр шинэчлэн ажиллаж байна. Майл хаяг болон бусад холбогдох мэдээллүүдийн өөрчлөлтүүдийг тусгасан.

АЛБАН ХААГЧИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ

/хуулийн 8.3.6/

Төсөвт байгууллагуудын байгууллагын болон албан хаагчдын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, дүгнэхдээ Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн “Аргачлал загвар батлах тухай” 100 дугаар тушаалын 10-н хавсарлтыг мөрдөн ажиллаж байна.

